

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
3 ДУГААР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

| Д/д | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэл | Хувь |
|-----|---|---|---|------|
| 1. | 4.1.1.9.Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах | Нутгийн захиргааны дотоод удирдлагын “UB ERP” системд суурилсан дэд системүүдэд нэмэлт хөгжүүлэлт хийж бусад системтэй интеграц хийх API сервисийн модул болон системийн интерфэйсийг сайжруулах. | Одоогийн байдлаар “UB ERP” систем https://erp.ulaanbaatar.mn -д суурилсан дэд системүүдэд нэмэлт сайжруулалт хийгдэж байна. Үүнд: хүний нөөцийн дэд ситемд иргэний мэдээллийг ХУР системээс татаж оруулж байна. Ажил төлөвлөлтийн шинэ дэд системийн дэлгэцийн хар зураг батлагдаж хөгжүүлэлт хийж байна. Хөгжүүлэлтийн ажил 50%-тай байна. | 50% |
| 2. | 4.1.2.1 төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодын төлбөр хураах цэгийг цахимжуулах | Нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоодыг цахимжуулах төлбөрийн цахим систем нэвтрүүлэх туршилтын ажил хийгдэж байгаа бөгөөд цахим төлбөрийн системд дараах төлбөрийн арга хэрэгслийг нэвтрүүлээд байна. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Цахим төлбөрийн и-баримтын буцаан олголтоос суутгах; 2. Арилжааны банкуудын аппликэйшнд нэхэмжлэх үүсгэн төлөх; 3. Тээврийн хэрэгслийн үйлчилгээний нэгдсэн https://smartcar.mn/ системд нэхэмжлэх үүсгэж дараа төлбөрт байдлаар гэх мэт цаашид тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт сонголт бий болгох үүднээс бусад цахим төлбөрийн арга хэрэгслийг нэвтрүүлэхээр ажиллаж байна | 70% |

| | | | | |
|----|---|---|--|-----|
| | | | <p>Мөн Налайх дүүргийн тэрэлж, Сонгинохайрхан дүүргийн баруун туруун төлбөр авах цэгүүдэд төлбөрийн систем нэвтрүүлэх туршилтыг амжилттай гүйцэтгэн ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.</p> <p>Нийслэлийн товчоодын төлбөр авах цэгүүдэд төлбөрийн систем нэвтрүүлэх туршилтын ажил хийгдэж дууссан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p> | |
| 3. | | <p>Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, сургуулийн үйл ажиллагааг сайжруулах, суралцагчдад зайнаас суралцах боломжийг олгох, эцэг эхчүүдэд хүүхдүүдийнхээ боловсрол эзэмших үйл явцад оролцох оролцоог дэмжих боловсролын нэгдсэн платформыг бий болгох</p> | <p>Нийслэлийн Ерөнхий боловсролын 40 сургуульд нэвтрүүлэх багш сурагч, эцэг эхийн удирдлагын eschool, estudent, eteacher, eparent системүүдийн хөгжүүлэлт бэлэн болсон. Сургууль дээр суурилуулагдах сурагчийн өөртөө үйлчлэх киоск машины угсралтын ажил явагдаж байна. 10 дугаар сарын 03-ны өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд сонгогдсон сургуулиудад киоск машинууд суурилуулагдана. Сургуулийн автобус төслийн хүрээнд эхний шатны 23 автобусанд карт уншигч төхөөрөмжийг байршуулан угсралт суурилуулалтын ажил хийгдэж байна. Нэвтрүүлэлтийн бэлтгэл ажлын хүрээнд сургуулиудын захирал, сургалтын менежер, багш, хоол автобус хариуцсан ажилтан, админ гэх мэт ажилтнуудад зориулсан сургалтууд хувиарын дагуу явагдаж байна.</p> | 50% |
| 4. | 4.1.2.2 зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт | <p>Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас үзүүлж буй согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлүүдийг болон</p> | <p>Онлайн бизнес төвийн 2-р шатны хөгжүүлэлтээр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж буй 108 үйлчилгээг цахимжуулахаар ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас олгодог Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл олгох</p> | |

| | | | | |
|----|---|---|--|-----|
| | тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | барилга байгууламжтай холбоотой 100 гаруй үйлчилгээг бүрэн цахимжуулах "Онлайн бизнэс төв"-ийн II-р шатны хөгжүүлэлт | болон галын дүгнэлт олгох үйлчилгээг нэн тэргүүнд буюу 10 дугаар сарын 28-ны дотор хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ. Үүний дараа барилгын үйл ажиллагаатай холбоотой 70 гаруй үйлчилгээнүүдийн цахимжуулна. Системийн ажлын явц 30 хувьтай явагдаж байгаа ба төслийн менежментийн ажлууд бүрэн хийдэж дууссан. Үүнд: Системийн судалгаа, хэрэглэгчийн шаардлага тодорхойлох процессыг баталгаажуулах, Текник сервер тоног төхөөрөмжийн үзүүлэлт боловсруулах, ерөнхий бүтэц, архитектур, дэлгэцийн зураг боловсруулан хэрэгжүүлэх шийдэл гаргах, өөрчлөлтүүдийг тусгах гэх мэт. Системийн хөгжүүлэлтийн ажил явагдаж байна. | 30% |
| 5. | Өргөдөл гомдол мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол мэдээллийг цахим хэлбэрээр гаргах шийдвэрлэх хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | Иргэдээс тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөнтэй холбоотой өргөдөл гомдол санал хүсэлтийг smartcar.mn системээр дамжуулан гаргах, UB ERP системийн өргөдөл гомдолын модултай холбох, мөн иргэн аж ахуйн нэгж байгууллагаас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хандсан өргөдөл гомдлыг "digital UB" аппликейшнээр хүлээн авах сувгийг хөгжүүлэх | Нийслэлийн иргэд олон нийтэд зориулсан мэдээ мэдээлэл, захирамж тогтоолыг цаг алдалгүй түргэн шуурхай авах, олон нийтийн гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэх, иргэдийн амьдралын хэрэгцээнд тулгуурласан төрийн үйлчилгээ авах болон татвар төлбөрийг цахимаар төлөх Нийслэлийн бусад системүүдийг нэгтгэсэн, төр иргэн хоорондын харилцаа холбоог хангасан Ухаалаг хотын бусад бүхий л мэдээ мэдээллийг багтаасан "Digital UB" аппликейшнг нэвтрүүлэхээр ажиллаж байна. "Digital Ub" аппликейшн нь иргэдийн өдөр тутмын амьдралд түгээмэл тулгардаг асуудлууд дээр үндэслэн "Өргөдөл, гомдол, гаргах, Олон нийтээр асуудал хэлэлцүүлэн улмаар Нийслэлийн засаг даргын тамгын газрын хуралд хэлэлцүүлэх, өрх болон харьяа дүүргийн эмнэлэгүүдэд цаг захиалах, авто машины зогсоолын мэдээлэл авах, автобусны чиглэл болон автобусны буудлын мэдээлэл авах, үйлчилгээ эрхлэх | 70% |

| | | | | |
|---|--|--|--|-----|
| | | | тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх” зэрэг модулиуд дээр хэрэглэгчийн шаардлагыг боловсруулан загвар дизайныг бүрэн гаргаж батлуулсан. Дизайн спринтийн батлагдсаны дагуу ерөнхий шаардлагын хүрээнд хөгжүүлэлтийн ажил 70 хувьтай явагдаж байна. 2022 оны 10 сарын 15-ны байдлаар хэрэглээнд нэвтрүүлэн “Digital UB” аппликейшны нээлтийг хийхээр бэлтгэл хангаж байна. | |
| Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3 дугаар улирлын хэрэгжилтийн дундаж хувь: | | | | 54% |

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.САЙНХҮҮ

НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЗУЛ